

Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал (Хүйтний улирал буюу 2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сар)

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлдог.


2021-2022 оны хүйтний улирал буюу 2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сарын хугацааны Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад $\text{PM}_{2.5}$ тоосонцор 5 мкг/м^3 -ээр буюу 8%, PM_{10} тоосонцор 15 мкг/м^3 -ээр буюу 14%-аар, азотын давхар исэл 9 мкг/м^3 -ээр буюу 21%-аар тус тус их, хүхэрлэг хий 12 мкг/м^3 -ээр буюу 11%-аар бага байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м^3	
	Хүлцэх агууламж, мкг/м^3	2020 оны 10-12-р сар, 2021 оны 1-4-р сарын дундаж	2021 оны 10-12-р сар, 2022 оны 1-4-р сарын дундаж
$\text{PM}_{2.5}$ тоосонцор	50	60	65 (8%↑)
PM_{10} тоосонцор	100	107	122 (14%↑)
Азотын давхар исэл, NO_2	50	42	51 (21%↑)
Хүхэрлэг хий, SO_2	50	112	100 (11%↓)

Өмнөх онтой харьцуулахад: ↓ бага; ↑ их;

Улаанбаатар хотын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг Зураг 1-8 дахь хэсэгт харуулав.


$\text{PM}_{2.5}$ тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын $\text{PM}_{2.5}$ тоосонцрын дундаж агууламж, 2017-2022 он

2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM2.5 тоосонцрын дундаж агууламж 2017-2018 оноос 46%, 2018-2019 оноос 39%-иар тус тус бага, 2020-2021 оноос 8%-иар их, 2019-2020 оны мөн үеийн түвшинд байна.


Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын дундаж агууламжийг Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 2017-2018 онд 2.4 дахин, 2018-2019 онд 2.1 дахин, 2019-2020 онд 1.3 дахин, 2020-2021 онд 1.2 дахин, 2021-2022 онд 1.3 дахин тус тус их байна (Зураг 1).



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

2021-2022 оны хүйтний улиралд агаар дахь PM2.5 тоосонцрын сарын дундаж хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард ажиглагдаж 2020 оны 12 дугаар сарын дундажтай харьцуулахад 7%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.2 дахин их байна (Зураг 2).


PM10 тоосонцор



Зураг 3. Хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламж, 2017-2022 он

2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM10 тоосонцрын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2017-2018 оноос 25%-иар бага, 2018-2019 оноос 34%-иар бага байсан бол 2019-2020 оноос 9%, 2020-2021 оноос 14%-иар тус тус их байсан байна.


Сүүлийн 5 жилийн хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2017-2018 онд 1.6 дахин, 2018-2019 онд 1.8 дахин, 2019-2020, 2020-2021 онд 1.1 дахин, 2021-2022 онд 1.2 дахин тус тус их байна (Зураг 3).



Зураг 4. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

2021-2022 оны хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард ажиглагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.6 дахин их байна (Зураг 4).


Азотын давхар исэл (NO_2)



Зураг 5. Азотын давхар ислийн хүйтний улирлын дундаж агууламж, 2017-2022 он

2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сарын азотын давхар ислийн дундаж агууламж 2017-2018 оноос 13%, 2018-2019 оноос 20%, 2020-2021 оноос 21%-иар тус тус их байсан бол 2019-2020 оноос 2%-иар бага байна.


Сүүлийн 5 жилийн хүйтний улирлын азотын давхар ислийн дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2019-2020 онд 1.1 дахин их байна (Зураг 5).



Зураг 6. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

2021-2022 оны хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард ажиглагдаж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.4 дахин их байна (Зураг 6).


Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 7. Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламж, 2017-2022 он

2021 оны 10-12, 2022 оны 1-4 дүгээр сарын хүхэрлэг хийн дундаж агууламж 2017-2018 оноос 3 дахин, 2018-2019 оноос 2.7 дахин, 2019-2020 оноос 1.5 дахин тус тус их байсан бол 2020-2021 оноос 1.1 дахин бага байна.

Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2019-2020 онд 1.3 дахин, 2020-2021 онд 2.2 дахин, 2021-2022 онд 2 дахин тус тус их байна (Зураг 7).



Зураг 8. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2016-2021 он

2021-2022 оны хүйтний улиралд агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж хамгийн их агууламж 2022 оны 1 дүгээр сард ажиглагдсан бөгөөд 2021 оны мөн үетэй харьцуулахад 24%-иар бага, АЧС дахь ХА-тай харьцуулахад 3.3 дахин их байлаа. (Зураг 8)

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС